

# ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН 2026 ОНЫ I УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

*Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар*



САЛБАРЫН СТАТИСТИК



ЗУУЧЛАЛЫН МЭДЭЭ



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН




ХЯНАЛТ ШАЛГАЛТ



ДҮГНЭЛТ


## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ**

1. Хороо—Санхүүгийн зохицуулах хороо
2. ҮХХ—Үл хөдлөх хөрөнгө
3. ҮХХЗБ—Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага
4. ТЗ—Тусгай зөвшөөрөл
5. ХНХ—Хувь нийлүүлсэн хөрөнгө
6. АЗҮХХ—Арилжааны зориулалттай үл хөдлөх хөрөнгө
7. ҮЗҮХХ—Үйлдвэрийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө
8. ОСЗҮХХ—Орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө
9. м.кв—Метр квадрат




Тайлант улирлын байдлаар Хороонд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 298 хуулийн этгээд бүртгэгдсэн байна.

Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийн 95.6 хувь буюу 285 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа бол 4.4 хувь буюу 13 хуулийн этгээд нь хөдөө, орон нутаг (Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Төв аймгийн Зуунмод сум, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум)-т үйл ажиллагаа эрхэлж байна.



# СТАТИСТИК

Улаанбаатар хотод ҮХХЗБ-ын үйл ажиллагаа эрхэлж буй 285 хуулийн этгээдийн 34% нь Сүхбаатар, 27.4% нь Хан-Уул, 19.3% нь Баянзүрх, 10.2% нь Баянгол, 8.4% нь Чингэлтэй, 0.7% нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус үйл ажиллагаа эрхэлж байна.



Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй зуучлалын байгууллагууд нь 312 брокер, 1388 агенттайгаар үйл ажиллагаа эрхэлсэн. Брокеруудын 51.3 хувь буюу 160 нь эрэгтэй, 48.7 хувь буюу 152 нь эмэгтэй брокер байгаа бол агентуудын 34.8 хувь буюу 465 нь эрэгтэй, 65.2 хувь буюу 873 нь эмэгтэй агент байна.

## БРОКЕР

160



## АГЕНТ

465

152



873

# ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тайлант улиралд зуучлалын байгууллагууд 437 хувьцаа эзэмшигчийн 6,027,667.5 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 0.9 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 15.5 хувиар тус тус буурсан байна.

	ХНХ-ийн хэмжээ	ХЭ-ийн тоо
2025.I	7,172,359.2 ₮	441
2026.I	6,027,667.5 ₮	437

Зуучлалын байгууллагуудын хувьцаа эзэмшигчдийн 93.3 хувийг иргэд, 5.4 хувийг хуулийн этгээд, үлдсэн 1.3 хувийг иргэн хуулийн этгээд хамтран эзэмшиж байна.

93.3%

5.4%

1.3%



85.7%



8.9%



4.2%



1.2%




Зуучлалын байгууллагуудын ХНХ-ийн 85.7 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байгаа бол 14.3 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.



# ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант улиралд 9 хуулийн этгээдээс ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хянаж, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Мөн хуулийн этгээдүүдээс ХНХ-ийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, эрх бүхий албан тушаалтан, хаяг, байршил, брокер, агент, оноосон нэрийн өөрчлөлттэй холбоотой нийт 108 хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан шийдвэрлэсэн.

ХНХ-ийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт		1
Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт		13
Агентын өөрчлөлт		87
Хаяг, байршлын өөрчлөлт		5
Салбар нээх		1
Оноосон нэрийн өөрчлөлт		1

  
САНХҮҮГИЙН ЗӨХИЦҮҮЛАХ  
ХОРОО  
Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тогруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-51) 29 44 44, Факс: (976-51) 26 41 24,  
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn  
2026.04.21-ний № ЦБ-11/438  
танай 2026.04.09-ний №26/05

Танай компаниас ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх тухай хүсэлтийг тус Хорооны 2024 оны 648 дугаар тогтоолоор баталсан “Хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, аудитын үйлчилгээ үзүүлэхд Хороонд бүртгүүлэх тухай журам”-ын дагуу хянаж, “Аудитын үйлчилгээ үзүүлэгч”-ээр бүртгэсэн болно.




Мөн нэр бүхий 2 хуулийн этгээдийг үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад “Аудитын үйлчилгээ үзүүлэгч”-ээр бүртгэсэн.


# ЗУУЧЛАЛЫН МЭДЭЭ

*Худалдах, худалдан авах*

Тайлант улиралд 298 ҮХХЗБ нь давхардсан тоогоор 3,045 хэлцлээр 641.2 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийг 794,767,359.8 мянган төгрөгөөр худалдан борлуулах үйл ажиллагааг зуучлан 21,893,595.4 мянган төгрөгийн хөлс, шагнал олсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад талбайн хэмжээ 2 дахин, борлуулалтын үнийн дүн 47.6 хувиар өссөн үзүүлэлт юм.



Тайлант улиралд 1,912 хэлцлээр 150.8 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийг 58,906,131.5 мянган төгрөгөөр хөлслөх, хөлслүүлэх, түрээслэх, түрээслүүлэх үйл ажиллагааг зуучлан 3,870,714.7 мянган төгрөгийн шимтгэлийн орлого олсон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад талбайн хэмжээ 1.1 дахин, үнийн дүн 4.2 хувиар өссөн үзүүлэлт юм.



# ЗУУЧЛАЛЫН МЭДЭЭ


## Худалдах, худалдан авах

Зуучлалын байгууллагуудаар дамжуулан худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн хэлцлийн 82.5%-ийг орон сууц, 7.6%-ийг газар, 5.6%-ийг АЗҮХХ, 3.9%-ийг авто зогсоол, 0.4 %-ийг ҮЗҮХХ тус тус эзэлж байна.

Зуучлалын байгууллагуудаар дамжуулан худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 84.5%-ийг орон сууц, 11.0%-ийг АЗҮХХ, 2.8%-ийг газар, 0.9%-ийг ҮЗҮХХ, 0.8%-ийг автозогсоол тус тус эзэлж байна.



Зуучлалын байгууллагуудаар дамжуулан худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн талбайн хэмжээний 74.9%-ийг 201м.кв-аас дээш талбайтай ҮХХ, 13.5%-ийг 51-100м.кв талбайтай ҮХХ, 7.5%-ийг 0-50м.кв талбайтай ҮХХ, 4.1%-ийг 101-200 м.кв талбайтай ҮХХ эзэлж байна.



# ЗУУЧЛАЛЫН МЭДЭЭ


Хөлслөх, хөлслүүлэх, түрээслэх, түрээслүүлэх

Зуучлалын байгууллагуудаар дамжуулан хөлслүүлж, түрээслүүлсэн үл хөдлөх хөрөнгийн хэлцлийн 75.7%-ийг орон сууц, 19.1%-ийг АЗҮХХ, 2.9%-ийг авто зогсоол, 2.2%-ийг ҮЗҮХХ, 0.1%-ийг газар тус тус эзэлж байна.

Зуучлалын байгууллагуудаар дамжуулан хөлслүүлж, түрээслүүлсэн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 59.0%-ийг орон сууц, 35.9%-ийг АЗҮХХ, 4.4%-ийг ҮЗҮХХ, 0.6%-ийг автозогсоол, 0.1%-ийг газар тус тус эзэлж байна.



Зуучлалын байгууллагуудаар дамжуулан хөлслүүлж, түрээслүүлсэн үл хөдлөх хөрөнгийн талбайн хэмжээний 19.5%-ийг 201м.кв-аас дээш талбайтай ҮХХ, 38.0%-ийг 51-100м.кв талбайтай ҮХХ, 22.8%-ийг 0-50м.кв талбайтай ҮХХ, 19.7%-ийг 101-200 м.кв талбайтай ҮХХ эзэлж байна.



# ЗУУЧЛАЛЫН МЭДЭЭ

Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй 298 ҮХХЗБ-аас ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд Сүхбаатар дүүрэгт орон сууцны зориулалттай ҮХХ-ийн 1 м.кв нь дунджаар 4,876,092.1 төгрөг буюу хамгийн өндөр дүнтэй борлуулагдсан бол Сонгинохайрхан дүүрэгт 3,248,124.5 төгрөг буюу хамгийн бага дүнтэй борлуулагдсан байна.

**Сүхбаатар дүүрэг**

4,876,092.1



₮

**Чингэлтэй дүүрэг**

4,382,412.6



₮

**Баянгол дүүрэг**

4,336,316.5



₮

**Хан-Уул дүүрэг**

4,189,097.9



₮

**Баянзүрх дүүрэг**

3,899,803.1



₮

**Сонгинохайрхан  
дүүрэг**

3,248,124.5



₮

# ЗУУЧЛАЛЫН МЭДЭЭ

*Үл хөдлөх хөрөнгийн менежментийн үйлчилгээ*

ҮХЭХЗ-ын байгууллагууд 883 хэлцлээр 82.7 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгөд 2,369,524.8 мянган төгрөгийн менежментийн үйлчилгээ үзүүлж 1,451,607.9 мянган төгрөгийн зуучлалын хөлс олжээ.

**883**

хэлцэл

**82.7**

мянган м.кв

**2,369,524.8**

мянган төгрөг

*Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйлчилгээнд хамаарах бусад үйл ажиллагаа*

Тайлант улиралд зуучлалын байгууллагууд 30 хэлцлээр 1,935,942.6 мянган төгрөгийн үнийн дүн бүхий үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаанд хамаарах бусад үйлчилгээг эрхэлсэн байна.



**30** хэлцэл

**1,935,942.6**

мянган төгрөг

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2025.I (мянган төгрөгөөр)	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2026.I (мянган төгрөгөөр)	Нийт хөрөнгөд эзлэх хувь
<b>ХӨРӨНГӨ</b>				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,797,720.4	6.2%	13,206,973.3	6.1%
Дансны авлага	49,164,692.9	22.3%	48,520,260.3	22.6%
Татвар, НДШ – ийн авлага	618,183.3	0.3%	923,608.2	0.4%
Бусад авлага	22,778,010.1	10.3%	26,525,224.6	12.4%
Бусад санхүүгийн хөрөнгө	3,148,286.2	1.4%	7,857,938.7	3.7%
Бараа материал	18,466,923.8	8.4%	12,503,878.8	5.8%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	14,572,191.9	6.6%	18,455,246.0	8.6%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,660,138.2	0.8%	1,534,747.9	0.7%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	38,164,413.8	17.3%	33,217,825.3	15.5%
Эргэлтийн хөрөнгийн дүн	162,370,560.5	73.6%	162,745,703.1	75.8%
Үндсэн хөрөнгө	31,909,675.4	14.5%	32,547,073.4	15.2%
Биет бус хөрөнгө	1,736,263.6	0.8%	1,608,804.5	0.7%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,420,935.6	4.3%	4,547,205.7	2.1%
Хойшлогдсон татварын хөрөнгө	44,365.9	0%	121,052.8	0.1%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	89,627.7	0%	89,627.7	0.0%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	14,920,398.1	6.8%	13,151,154.3	6.1%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	58,121,266.4	26.4%	52,064,918.4	24.2%
Нийт хөрөнгийн дүн	220,491,826.9	100%	214,810,621.4	100.00


# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2025.I (мянган төгрөгөөр)	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2026.I (мянган төгрөгөөр)	Нийт хөрөнгөд эзлэх хувь
Дансны өглөг	46,800,135.6	21.3%	45,156,977.7	21.0%
Цалин, татвар, НДШ-ийн өглөг	15,486,910.8	7%	17,127,503.0	8.0%
Банкны богино хугацаат зээл	3,775,295.5	1.7%	2,639,368.0	1.2%
Хүүний өглөг	9,058,205.8	4.1%	8,303,078.2	3.9%
Ногдол ашгийн өглөг	696,600.0	0.3%	2,000,000.0	0.9%
Урьдчилж орсон орлого	35,376,363.1	16%	32,118,660.1	15.0%
Нөөц /өр төлбөр/	168,030.4	0.1%	280,292.1	0.1%
Бусад богино хугацаат өр төлбөр	41,994,022.9	19.1%	42,907,862.3	20.0%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	1,766,561.2	0.8%	202,853.8	0.1%
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>155,122,125.4</b>	<b>70.4%</b>	<b>150,736,595.2</b>	<b>70.2%</b>
Урт хугацаат зээл	21,267,266.6	9.6%	18,356,069.7	8.5%
Нөөц /өр төлбөр/	3,083.7	0%	5,383.5	0.0%
Хойшлогдсон татварын өр	546,089.5	0.3%	577,026.7	0.3%
Бусад урт хугацаат өр төлбөр	842,802.9	0.4%	3,656,034.5	1.7%
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>22,659,242.7</b>	<b>10.3%</b>	<b>22,594,514.4</b>	<b>10.5%</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>177,781,368.1</b>	<b>80.7%</b>	173,331,109.6	80.7%
Өмч	7,172,359.2	3.3%	6,027,667.5	2.8%
- хувийн	7,172,359.2	3.3%	6,027,667.5	2.8%
Нэмж төлөгдсөн капитал	69,120.0	0%	104,850.6	0.0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	291,030.9	0.1%	626,847.2	0.3%
Эздийн өмчийн бусад хэсэг	6,195,564.9	2.8%	6,210,988.6	2.9%
Хуримтлагдсан ашиг	28,982,383.8	13.1%	28,509,158.0	13.3%
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>42,710,458.8</b>	<b>19.3%</b>	<b>41,479,511.8</b>	<b>19.3%</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>220,491,826.9</b>	<b>100%</b>	<b>214,810,621.4</b>	<b>100.0%</b>


# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2025.I


Тайлант улиралд ҮХХЗБ-ын салбарын нэгтгэлд нийт 302 ҮХХЗБ 100 хувийн ирцтэйгээр хамрагдлаа. Тайлант хугацаанд зуучлалын байгууллагууд нийт 441 хувьцаа эзэмшигчийн 7,172,359.2 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 220,491,826.9 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.




Эргэлтийн хөрөнгө



Эргэлтийн бус хөрөнгө




Эздийн өмч




Өр төлбөр

## 2026.I


Тайлант улиралд ҮХХЗБ-ын салбарын нэгтгэлд нийт 298 ҮХХЗБ 100 хувийн ирцтэйгээр хамрагдлаа. Тайлант хугацаанд зуучлалын байгууллагууд нийт 437 хувьцаа эзэмшигчийн 6,027,667.5 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 214,810,621.4 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.




Эргэлтийн хөрөнгө



Эргэлтийн бус хөрөнгө



Эздийн өмч



Өр төлбөр

# ОРЛОГЫН ТАЙЛАН

2025.I

**3,552,916.0**  
мянган төгрөг

**53,265,270.8**  
мянган төгрөг

**50,958,315.9**  
мянган төгрөг

**56,818,186.8**  
мянган төгрөг

Цэвэр  
ашиг

Нийт  
зардал

Борлуулалтын  
орлого

Нийт  
орлого

2026.I

**1,889,030.8**  
мянган төгрөг


**51,923,015.0**  
мянган төгрөг

**51,335,312.2**  
мянган төгрөг


**53,812,045.8**  
мянган төгрөг

- \* Тайлант улиралд зохицуулалттай этгээдүүд нь 53,812,045.8 мянган төгрөгийн нийт орлоготой, 51,923,015.0 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- \* Мөн зуучлалын байгууллагууд нь 1,889,030.8 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 46.8 хувиар буурсан үзүүлэлт юм.
- \* Зуучлалын байгууллагуудын нийт орлогын 95.4 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.

# ОРЛОГЫН ТАЙЛАН



ҮХХЗБ-уудын нийт орлого болох 53,812,045.8 мянган төгрөгийн 95.4 хувийг борлуулалтын орлого, 1.7 хувийг түрээсийн орлого эзэлж байгаа бол 2.9 хувийг бусад орлого эзэлж байна.



ҮХХЗБ-уудын нийт зардал болох 51,923,015.0 мянган төгрөгийн 44.2 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 39.1 хувийг ерөнхий ба удирдлагын зардал, 10.4 хувийг борлуулалт, маркетингийн зардал эзэлж байгаа бол 8.3 хувийг бусад зардал эзэлж байна.

# БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ



“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын олон улсын хууль, эрх зүйн орчны судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг Хорооны Ажлын албаны даргаар 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр батлуулав.



Хорооны 2024 оны 648 дугаар тогтоолоор баталсан журмын нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал авахаар Хорооны цахим хуудсанд байршууллаа.

## СУРГАЛТ



Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын агентад эрх олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж, тус сургалтад 261 оролцогчийг хамруулсан бөгөөд брокерт эрх олгох сургалтыг 1 удаа зохион байгуулж, 14 оролцогч хамрагдлаа.



Зайн хяналтаар илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, тайлагналтыг сайжруулах хүрээнд үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын гүйцэтгэх захирал болон нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр 2026.03.13-ны өдөр зохион байгуулж, салбарын 90 оролцогчийг хамрууллаа.

# ХЯНАЛТ ШАЛГАЛТ



Тайлант улиралд 289 санхүүгийн тайлан, 205 зуучлалын мэдээ ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан.



Зайны хяналт шалгалтын хүрээнд 171 хуулийн этгээдэд тайлангийн хариу хүргүүлсэн.



Нэр бүхий 18 компаниас ирүүлсэн улсын байцаагчийн албан шаардлагын биелэлтийг тооцсон.



Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цагалварт тусгагдсан “Орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаар мэдээлэл сонсох” ажлын хүрээнд Өргөдлийн байнгын хорооноос 2026.03.12-ны өдөр зохион байгуулсан “Санал солилцох уулзалт”-д оролцож, Хороонд 2020-2025 онд ирсэн захиалгын гэрээний маргаантай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг танилцуулсан.



Цагдаагийн Ерөнхий Газарт гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тухай мэдээлэл холбогдох баримт бичгийг нэмж бүртгүүлэхээр Хорооны 2026.03.25-ны өдрийн ЦБ-11/311 тоот албан бичгээр гомдол хүргүүлсэн.



Тайлан мэдээний Фина системд холбогдох тохируулга, сайжруулалтыг МТХ-тэй хамтарч хийсэн.



Газар дээрх шалгалтын 2026 оны төлөвлөгөөг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

# ДҮГНЭЛТ

Хороонд 2026 оны I улирлын байдлаар 298 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага бүртгэгдсэн байна.

Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй зуучлалын байгууллагууд нь 312 брокер, 1388 агенттайгаар үйл ажиллагаа эрхэлсэн.

Тайлант улиралд зуучлалын байгууллагууд 437 хувьцаа эзэмшигчийн 6,027,667.5 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй үйл ажиллагаа эрхэлсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчийн тоо 0.9 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 15.5 хувиар тус тус буурсан байна.

Зуучлалын байгууллагуудын ХНХ-ийн 85.7 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байгаа бол 14.3 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Тайлант улиралд 9 хуулийн этгээдээс ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт, 108 бүртгэлийн хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан шийдвэрлэсэн.

Тайлант улиралд 298 ҮХХЗБ нь давхардсан тоогоор 3,045 хэлцлээр 641.2 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийг 794,767,359.8 мянган төгрөгөөр худалдан борлуулах үйл ажиллагааг зуучлан 21,893,595.4 мянган төгрөгийн хөлс, шагнал олсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад талбайн хэмжээ 2 дахин, борлуулалтын үнийн дүн 47.6 хувиар өссөн үзүүлэлт юм.

# ДҮГНЭЛТ

Тайлант улиралд 1,912 хэлцлээр 150.8 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийг 58,906,131.5 мянган төгрөгөөр хөлслөх, хөлслүүлэх, түрээслэх, түрээслүүлэх үйл ажиллагааг зуучлан 3,870,714.7 мянган төгрөгийн шимтгэлийн орлого олсон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад талбайн хэмжээ 1.1 дахин, үнийн дүн 4.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй 298 ҮХХЗБ-аас ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд Сүхбаатар дүүрэгт орон сууцны зориулалттай ҮХХ-ийн 1 м.кв нь дунджаар 4,876,092.1 төгрөг буюу хамгийн өндөр дүнтэй борлуулагдсан бол Сонгинохайрхан дүүрэгт 3,248,124.5 төгрөг буюу хамгийн бага дүнтэй борлуулагдсан байна.

Зуучлалын байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 214,810,621.4 мянган төгрөг бөгөөд нийт хөрөнгийн 75.8 хуийг эргэлтийн хөрөнгө, 24.2 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант улиралд зохицуулалттай этгээдүүд нь 53,812,045.8 мянган төгрөгийн нийт орлоготой, 51,923,015.0 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Мөн зуучлалын байгууллагууд нь 1,889,030.8 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 46.8 хувиар буурсан үзүүлэлт юм.



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**